

ЗӨВШӨӨРСӨН:

ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ХӨГЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ДАРГА.....

С.ТӨГСДЭЛГЭР

БАТЛАВ:

ХАВДАР СУДЛАЛ МЭРГЭЖЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ДАРГА.....

Я.ЭРДЭНЭ-ОЧИР

“ХИМИ ЭМЧИЛГЭЭ СУДЛАЛ”

ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

СУРГАЛТ ЭРХЛЭХ БАЙГУУЛЛАГА: ХАВДАР СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

ИНДЕКС: S/s/0912-15-02

ХУГАЦАА: 1 ЖИЛ

УЛААНБААТАР ХОТ

2023.12.04

БОЛОВСРУУЛСАН АЖЛЫН ХЭСЭГ:

Я.Замбалгарав, Хавдар судлалын үндэсний төвийн Хими эмчилгээний тасгийн эрхлэгч, Хавдар судлалын тэргүүлэх зэргийн эмч

Д.Алтанцэцэг, Хавдар судлалын үндэсний төвийн Хими эмчилгээний тасгийн эмч, АУ-ны магистр, Хавдар судлалын тэргүүлэх зэргийн эмч

Ц.Цолмонтуяа, Хавдар судлалын үндэсний төвийн Хими эмчилгээний тасгийн эмч, Хавдар судлалын ахлах зэргийн эмч, АУ-ны магистр

Э.Сайханцэцэг, Хавдар судлалын үндэсний төвийн Хими эмчилгээний тасгийн эмч, АУ-ны магистр, Хавдар судлалын тэргүүлэх зэргийн эмч

Н.Орхон, Хавдар судлалын үндэсний төвийн Хими эмчилгээний тасгийн эмч, Хавдар судлалын тэргүүлэх зэргийн эмч

Д.Наран, Хавдар судлалын үндэсний төвийн Хими эмчилгээний тасгийн эмч, Хавдар судлалын ахлах зэргийн эмч

ХАМТРАН АЖИЛЛАСАН:

Т.Лхагва-Очир, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүн, Анагаах ухааны доктор

Ц.Бадамсүрэн, Хавдар судлалын үндэсний төвийн Нийгмийн эрүүл мэнд, төлөвлөлт, сургалтын албаны дарга, Анагаах ухааны доктор

ХЯНАСАН:

Я.Эрдэнэ-Очир, ХСҮТ-ийн Мэс заслын зөвлөх, ЭМЯ-ны Хавдар судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн тэргүүн, АУ-ны доктор

“ХИМИ ЭМЧИЛГЭЭ СУДЛАЛ” ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

НЭГ. ҮНДЭСЛЭЛ

Хорт хавдрын судалгааны олон улсын агентлаг (ХХСОУА)-ийн мэдээлснээр дэлхий дахинаа 5 хүн тутмын 1 нэг нь амьдралынхаа туршид хорт хавдраар өвчилдөг ба 21-р зууны нийгмийн эрүүл мэндийн хамгийн чухал асуудлын нэг нь хавдрын урьдчилан сэргийлэлтийн асуудал болоод байгааг тэмдэглэсэн байна. Орчин үеийн шинжлэх ухааны ололт, судалгаа шинжилгээний үр дүнгээр, хавдрын анхдагч урьдчилан сэргийлэлтийн үр дүнтэй арга хэмжээг авч хэрэгжүүлбэл нийт хорт хавдрын тохиолдлын хамгийн багадаа 40%-иас сэргийлэх ба цаашилбал хавдрын эрт илрүүлгийг нэмэгдүүлснээр нас баралтыг бууруулж чадна гэж тооцоолж байна.

Дэлхийн 185 орныг хамруулсан ХХСОУА-ийн 2020 оны тайлангаас харахад дэлхий дахинаа 100000 хүн амд ногдох хорт хавдрын өвчлөлийн түвшин 190 байхад манай улсад 215, үүний дотор хөхний хорт хавдрын өвчлөлөөр нэгдүгээрт, бүдүүн-шулуун гэдэсний болон түрүү булчирхайн хорт хавдрын өвчлөлөөр тус бүр хоёрдугаарт эрэмбэлэгдэж байна. Харин 100000 хүн амд ногдох хорт хавдрын нас баралтын түвшин дэлхий дахинд 100,1 байхад манай улсад 176,2 ногдож байгаагаар нэгдүгээрт эрэмбэлэгдэж байна. Ялангуяа элэгний хорт хавдрын нас баралтаар дэлхийн түвшингээс 10 дахин өндөр, ходоодны хорт хавдрын нас баралтаар 3 дахин өндөр үзүүлэлттэйгээр тус бүр нэг ба гуравдугаарт эрэмбэлэгдэж байна¹.

Сүүлийн 20 жилийн байдлаар Монгол улсын хүн амын нас баралтын тэргүүлэх шалтгааныг зүрх судасны тогтолцооны өвчин, хорт хавдар эзэлж байна. Хавдар судлалын үндэсний төв (ХСҮТ)-ийн 2022 оны тайлангаас харахад нийт 6885 хорт хавдрын шинэ тохиолдол бүртгэгдсэний 70 хувь нь хожуу буюу үе шатандаа оношилогдож, 66 хувь нь 1 жил хүрэхгүй нас баржээ². Хавдрыг эрт үед нь оношилсноор төгс эмчлэх боломжтой байдаг хэдий ч манай улсад хорт хавдраар шинээр өвчлөгсдийн 70 гаруй хувь нь ийнхүү хожуу үе шатанд оношлогдож байгаатай холбоотой ХСҮТ-ийн Хими эмчилгээний тасгаар эмчлүүлэгсдийн тоо жилээс жилд нэмэгдсээр энэхүү тусламжийг орон нутагт хөгжүүлэх хэрэгцээ шаардлага улам бүр өсч байна. Тухайлбал 2018 онд хорт хавдрын улмаас химийн эмчилгээнд 5500 хүн эмчлэгдэж байсан бол 2023 онд энэ тоо **... болж, ...%-иар** өссөн үзүүлэлттэй байгаагаас харж болно³. Хими эмчилгээг зөвхөн ХСҮТ-д хийж байсан нь ачаалал, хүлээгдлийг нэмэгдүүлж, үйлчлүүлэгчдэд зайлшгүй шаардлагатай эмчилгээ, үйлчилгээг авахын тулд сэтгэл санаа болоод эдийн засгийн хувьд ихээхэн дарамтыг бий болгож байсан.

Монгол улсын Эрүүл мэндийн салбарт 2020 оноос хэрэгжиж байгаа санхүүжилтийн шинэчлэлийн хүрээнд эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх анхан, лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээний багцад яаралтай

¹ International Agency for Research on Cancer

² Хавдар судлалын үндэсний төвийн статистикийн тайлан, 2022

³ ХСҮТ-ийн Хими эмчилгээний тасгийн тайлан, 2022

тусламж, эрчимт эмчилгээ, хорт хавдар, гэмтэл, түлэгдэлт, тархины цус харвалтын зэрэг нэн шаардлагатай тусламж, үйлчилгээг оруулан баталж, гүйцэтгэлээр санхүүжүүлж эхэлсэнтэй холбоотой энэ төрлийн тусламж үйлчилгээний хүртээмж нэмэгдэж байгаа ч хими эмчилгээний үр дүн, чанарын асуудал чухлаар тавигдах болсон. Түүнчлэн хими эмчилгээний хувьд хамгийн үр дүнтэй бай эмчилгээг хөгжүүлэх зайлшгүй шаардлага тулгарч байна.

Хими эмчилгээ нь цитотоксик болон цитостатик үйлдэлтэй нэг болон хэд хэдэн эмийн хослолоор хийгддэг бөгөөд тухайн өвчнийхөө үе шатаас хамаарч тодорхой давтамжтайгаар дунджаар 4-6 удаа, зарим тохиолдолд түүнээс ч олон удаа хийгддэг хорт хавдрын өвөрмөц эмчилгээний нэг төрөл юм.

Эрүүл мэндийн сайдын 2007 оны 242 дугаар тушаалаар “Орон нутагт хорт хавдар өвчний хими эмчилгээг нэвтрүүлэх тухай”, 2017 оны А/337 дугаар тушаалаар “Журам шинэчлэн батлах тухай” тушаалын хэрэгжилтийг хангах зорилгоор 2014 оноос эхлэн тус төвд аймаг, дүүргийн хавдар судлаач эмч нарыг “Хими эмчилгээ судлал” төрөлжсөн мэргэшлийн 6 сарын хугацаатай сургалтанд хамруулж эхэлсэн. Хими эмчилгээний мэргэшсэн эмчийг бэлтгэснээр үйлчлүүлэгчдэд үйлчилгээг ойртуулж, хүлээгдэл, чирэгдлийг бууруулахад тодорхой ахиц гарч байгаа хэдий ч сүүлийн үед ховор тохиолдлын хорт хавдрууд нэмэгдэж байгаатай холбоотой сургалтын хөтөлбөрийн агуулгыг шинэчлэх, бай эмчилгээг хөгжүүлэх болон сургалтын төгсгөлийн үнэлгээнд үндэслэн хөтөлбөрийн үргэлжлэх хугацааг 12 сар болгох шаардлага тулгарч байна.

Цаашид хавдрын тусламж үйлчилгээний төвлөрлийг сааруулж, аймаг, дүүргийн түвшинд өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагад хавдрын бүхий л төрлийн тусламж үйлчилгээг авах нөхцөлийг бүрдүүлснээр иргэд хүлээгдэл, чирэгдэлгүй, санхүүгийн дарамтгүйгээр чанартай тусламж үйлчилгээг тэгш хүртээмжтэй авах боломжийг бий болгох зорилго салбарын өмнө тулгамдаж байна. Уг зорилгыг хангах хүрээнд эрүүл мэндийн салбарын бүх шатлалд өмчийн бүх хэлбэрийн эмнэлгүүдэд олон улсын жишигт хүрсэн хавдрын хими эмчилгээгээний тусламжийг үзүүлэх чадвартай хими эмчилгээний эмчийг бэлтгэхийн тулд “Хими эмчилгээ судлал” төрөлжсөн мэргэшлийн сургалтын хөтөлбөрийг олон улсын жишигт нийцүүлэн, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/337 дугаар тушаал, Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн 2019 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн хурлын тогтоолыг баримтлан шинэчлэн боловсрууллаа.

ХОЁР. ЭРХЭМ ЗОРИЛГО

Хорт хавдартай эмчлүүлэгчдийн биеийн байдлыг зөв үнэлэн тохирох Хими эмчилгээг бие даан хийх, гарсан үр дүнг хянах, гарч болзошгүй гаж нөлөө ба хүндрэлээс урьдчилан сэргийлэх, эмчлэх, хянах чадвартай мэргэшсэн эмчийг бэлтгэхэд зорилго оршино.

ГУРАВ. АЛСЫН ХАРАА

3.1 Хими эмчилгээ судлал төрөлжсөн мэргэжлийн сургалтын хөтөлбөрөөр бэлтгэх эмчийн дүр зураг:

Хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх үүрэг хариуцлагаа бүрэн ойлгосон, хорт хавдрын оношилгоо, эмчилгээ, хяналтын талаар шаардлагатай мэдлэг, ур чадварыг эзэмшсэн, үйлчлүүлэгчийг энэрэх хайрлах сэтгэлээр хандаж, эмчийн ёс зүйг чандлан баримталдаг, багаар ажиллах чадвартай эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үр дүнтэй үзүүлж чаддаг Хавдар судлаач эмч байна.

Мөн Хавдар судлаач эмч нь хавдрын өвөрмөц эмчилгээ болох хими эмчилгээг хөгжүүлэх цөм чадамжтай байна.

3.2 Хавдар судлаач эмчийн цөм чадамж

Алсын харааг биелүүлэхэд чиглэсэн дараах цөм чадамжтай байна.

1. Хими эмчилгээний эмч
2. Мэргэжлийн байх
3. Суралцагч
4. Харилцагч
5. Хамтрагч
6. Хүн амын эрүүл мэндийн зөвлөгч
7. Зохион байгуулагч, манлайлагч

ДӨРӨВ. СУРГАЛТЫН ЗОРИЛТ

Хүний бие махбодийн эрхтэн системийн хорт хавдрын үе шатыг эд, эсийн шинжилгээний дүгнэлтийг дүрсийн болон бусад шинжилгээтэй харьцуулан гаргаж, өвчтөн бүрийн онцлогт тохирсон хими эмчилгээний төлөвлөгөөг гаргаж, улмаар химийн эмчилгээний бодис болон гадны биетээр эмчлэх аргуудад суралцаж, бие даан гүйцэтгэх чадварт суралцах

Цөм чадамж бүхий эмч болохын тулд дараах дэд чадамжийг эзэмшиж, бие даан гүйцэтгэж чаддаг болно.

I. Хими эмчилгээний эмч (Medical oncologist)

- Хими эмчилгээний эмүүдийн ангилал, үйлчлэх механизм, зарчмыг мэдэх
- Хими эмчилгээ хийх заалт, эсрэг заалтыг мэдэх
- Эмийн тунг зөв тооцоолж сурах
- Эд, эсийн шинжилгээний хариуг уншиж ойлгон дүгнэлтийг дүрсийн болон бусад шинжилгээтэй харьцуулан гаргаж эмчилгээний төлөвлөгөө гаргаж эмчлэх
- Төрөл бүрийн байрлалын хавдруудын үед хийх тохирсон хими эмчилгээний схемийг сонгон эмчлэх
- Хими эмчилгээ хийх аргуудыг эзэмших
- Амбулаторийн нөхцөлд өдрийн хими эмчилгээг хийх аргыг эзэмших

- Хими эмчилгээний үед гарч болох гаж нөлөө, авах арга хэмжээ
- Өвчтөний хувийн нууцыг хадгалах
- Хими эмчилгээний дараах өвчтөний хяналтыг хийх
- Эмчилгээний үр дүнг тооцож, судалгаа, дүгнэлт гаргах
- Химийн эмчилгээний явцад болон дараа нийгмийн харилцаанд хэвийн оролцох, гоо зүйн талаас гарсан өөрчлөлтийн улмаас өвчтөнд үүсэх эмнэл зүй болоод сэтгэл зүйн гэмтлийн онцлогийг ойлгон мэдэрч өвчтөн болон ар гэр, садан төрлийнхөнтэй нь хүндэтгэлтэй хялбар үгээр харилцах, зөвлөх, энэ талаар хяналтын бусад эмч мэргэжилтнүүдтэй хамтран ажиллах, тэдгээрт зөвлөмж өгөх
- Хорт хавдрын эцсийн шатанд орсон, хөнгөвчлөх зорилгоор химийн эмчилгээ хийлгэж байгаа өвчтөн болон түүний ар гэрийн амьдралын чанарт гарах өөрчлөлтийг ойлгон, тэдэнд нөхцөл байдлыг ойлгуулах, хэцүү байдлаас урьдчилан сэргийлэхэд туслах, дэмжих, хөнгөвчлөх тусламжийг бусад эмч нартай хамтран үзүүлэх
- Эмнэлгийн бусад тасгийн эмч нар болон бусад эмнэлгийн эмч нартай мэргэжлийн мэдлэг мэдээллээ хуваалцан хамтран ажиллах
- Эмчийн ёс зүй болон хүний ёс зүйг эрхэмлэдэг, зөв хандлагатай, багаар ажиллах

II. Мэргэжлийн байх (Professionalism):

- Орон нутагт өөрийн мэргэшлээр хувь нэмэр оруулах хүсэл эрмэлзэлтэй байх
- Өвчтөнийг хувь хүний хувьд хүндэтгэж, хамгийн оновчтой зөв шийдвэр гаргахын төлөө ажиллах
- Хувь хүний онцлогийг харгалзан өвчтөн болон түүний гэр бүлийн гишүүн, асран хамгаалагч, төрөл, садны хүнтэй хүндэтгэлтэй харилцах

III. Суралцагч (Learner):

- Өөрийн мэдлэг, ур чадвараа дээшлүүлэхийн тулд хэрэгцээт сургалтанд хамрагдах
- Өдөр тутам шинэчлэгдэж байгаа анагаах ухааны дэвшлээс хоцрохгүйн тулд бие даан тасралтгүйгээр суралцах, олон төрлийн мэдээллийн эх үүсвэрийг судлах, дүн шинжилгээ хийх
- Хамтран суралцагч эмч, бусад эмнэлгийн мэргэжилтэнд заах замаар өөрийн мэдлэг, ур чадвараа сайжруулах

IV. Харилцагч (Communicator):

- Өвчтөн болон түүний гэр бүлийн гишүүн, асран хамгаалагч, төрөл, садны хүнтэй зүй зохистой үг хэллэг ашиглан зөв боловсон харилцах
- Өвчтөнд шаардлагатай мэдээлэл өгөхдөө ойлгоход хялбар үг хэллэг ашиглан тайлбарлах
- Шаардлагатай тохиолдолд өвчтний оношилгоо, эмчилгээний талаар бусад эмнэлгийн мэргэжилтэнтэй зөвлөлдөх

V. Хамтрагч (Collaborator):

- Тухайн орон нутгийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй холбоотой асуудлаар мэргэшлийн эмч нартай мэдээлэл солилцож, хамтран ажиллах
- Эмнэлгийн бусад тасгийн эмч, эмнэлгийн мэргэжилтэнтэй мэргэжлийн мэдлэг, мэдээллээ хуваалцаж хамтран ажиллах

VI. Хүн амын эрүүл мэндийн зөвлөгч (Community Health Advocate):

- Хүн амын эрүүл мэндийн зөвлөгч байхын тулд урьдчилан сэргийлэх, тусламж, үйлчилгээ үзүүлэх, сургалт сурталчилгаа явуулах
- Хүн амын эрүүл мэндийн хэрэгцээнд тохирсон арга хэмжээг авч хэрэгжүүлэх

VII. Зохион байгуулагч, манлайлагч (Leader):

- Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг зохицуулах, манлайлан ажиллах үүргээ ухамсарлах;
- Эмнэлэг, эрүүл мэндийн төв дэх тусламж, үйлчилгээ үзүүлэх багийг манлайлан ажиллах үүргээ ухамсарлах.

ТАВ. СУРГАЛТЫН АРГА ЗҮЙ

6.1 Сургалтын чиглэл, хугацаа, байршил

- Сургалтад онош батлагдсан хими эмчилгээг төгс, төгс бус болон хөнгөвчлөх зорилгоор хийгдэж буй хими эмчилгээний тусламжийг бүлэглэсэн гурван тойролтоор эзэмшинэ.
- Сургалтын нийт хугацаа 1 жил байна.
- Нэг тойролтын хугацаа агуулга, сургалт эрхлэх хүчин чадлаас хамааран 12-15 долоо хоног байна.
- Суралцагч эмчийн өдөр тутмын болон долоо хоногийн үйл ажиллагаа хавсралтад буй эмнэл зүйн багшийн ажлын хуваарьтай уялдсан тойролтын хуваарийн дагуу явагдана.
- Хавдар судлалын үндэсний төвийн хими эмчилгээний тасаг уг сургалтыг эрхлэн явуулна. Үүнд амбулатори, хэвтэн эмчлүүлэх тасаг, өдрийн хими эмчилгээний тасаг, бүлгээр суралцах сургалтын танхим зэрэг газруудад сургалт явагдана.

5.2 Зайлшгүй танин мэдэж, суралцах шаардлагатай шинж тэмдэг, өвчин, гардан үйлдэл

Тайлбар: Тойролт бүрт суралцагч дараах эмнэл зүйн чадварыг эзэмшиж дадлагажина. Тойролт бүрийн хуваарьт агуулга буюу судлах өвчин эмгэг, хийж сурах гардан үйлдлийг жагсаасан бөгөөд хими эмчилгээний үеийн илэрч болох гаж нөлөө, хүндрэлүүд, авах арга хэмжээ, эмчилгээний үр дүнг тооцох дүрс оношлогооны мэдлэг, онцлог асаргаа сувилгааны болон бусад чадварыг тухайн тойролт тус бүрийн агуулгат багтаан үзэж эзэмшинэ.

- Өвчтөний биеийн ерөнхий эрүүл мэндийн байдал, одоогийн өвчний түүхийг нарийвчлан авч амьдралын, нийгмийн амьдралын болон удамшлын түүхээс уг

өвчний шалтгаан нөлөөллийг олж тогтоон өөрт нь болон асран хамгаалагчид нь зөвлөгөө өгөх, мэс засал, хими туяа эмчилгээний түүх, асран хамгаалагчийн дэмжлэг, асаргааны боломж байдал, орон нутгийн эмчийн талаарх мэдээллийг цуглуулан дүн шинжилгээ хийх

- Эмнэл зүйн сургагч багшийн хяналт дор амбулаторийн болон хэвтэн эмчлүүлж буй өвчтөнийг үзэж, оношилж эмчлэх явцдаа дараах шинж тэмдгүүд, өвчнийг таньдаг болж гардан үйлдлийг бие даан хийж туршлага хуримтлуулна.

5.2.1 Зайлшгүй танин мэдэх шаардлагатай эмгэгүүд:

	Эмгэгүүд	ICD 10
1	Тархины хорт хавдрын хими эмчилгээ	C70
2	Толгой хүзүүний байрлалын хорт хавдрын хими эмчилгээ	C01-C13
3	Арьсны хорт хавдрын үед хийгдэх хими эмчилгээний схемүүд	C43
4	Анхдагч тодорхойгүй хавдрын хими эмчилгээ	C76
5	Бамбай булчирхайн хорт хавдрын хими эмчилгээ	C73
6	Меланома хавдрын үед хийгдэх хими эмчилгээний схемүүд	C44
7	Тимома ба тимусын хорт хавдрын хими эмчилгээ	C32
8	Ясны хорт хавдрын үед хийгдэх хими эмчилгээ	C40
9	Уушигны гялтан хальсны хорт хавдрын хими эмчилгээ Уушгины хорт хавдрын үед хийгдэх хими эмчилгээ	C34
10	Улаан хоолой болон улаан хоолой ба ходоодны заагийн байрлалтай хавдрын хими эмчилгээ	C15
11	Ходоодны хавдрын хими эмчилгээ	C16
12	Нарийн гэдэсний хорт хавдрын хими эмчилгээ, Бүдүүн гэдэсний хавдрын хими эмчилгээ	C17-C19
13	Шулуун гэдэсний хорт хавдрын хими эмчилгээ	C20
14	Хоол боловсруулах замын стромын хавдар (GIST)-ын хими эмчилгээний зарчим	C
15	Элэгний хорт хавдрын системийн эмчилгээ	C22
16	Цөсний замын хавдрын хими эмчилгээ	C23
17	Нойр булчирхайн хорт хавдрын хими эмчилгээ	C25
18	Хөхний хорт хавдрын хими эмчилгээ	C50
19	Умайн хүзүүний хорт хавдрын хими эмчилгээ	C53
20	Умайн их биеийн хавдрын хими эмчилгээ	C52
21	Нейроэндокрин хавдрын хими эмчилгээ	C
22	Өндгөвч ба хэвлийн гялтан хальсны хорт хавдрын хими эмчилгээ	C56
23	Бэлгийн уруулын хорт хавдрын хими эмчилгээ	C57
24	Үтрээний хорт хавдрын хими эмчилгээ	C
25	Хорионкарцинома хими эмчилгээ	C54
26	Бөөрний хавдрын хими эмчилгээ	C67
27	Давсагны хорт хавдрын хими эмчилгээ	C65
28	Түрүү булчирхайн хорт хавдрын хими эмчилгээ	C61
29	Бөөрний дээд булчирхайн хавдрын хими эмчилгээ	C
30	Шодойн хавдрын хими эмчилгээ	C
31	Төмсөгний хавдрын хими эмчилгээ	C62

32	Зөөлөн эдийн хавдрын хими эмчилгээ	C49
----	------------------------------------	-----

5.2.2 Зайлшгүй танин мэдэх шаардлагатай хам шинж, түүний менежмент:

	Хам шинж	Шаардлагатай шинжилгээ
1	Хордлогын хам шинж: Халуурах, шөнөөр хөлрөх, турах (B symptoms)	Биохими, ЦЕШ, ШЕШ
2	Тууралтат хам шинж: Биеийн ил хэсэгт гарсан үүсгэвэр, амны хөндийд эмчилгээнд эдгэрэхгүй цагаан улаан өнгийн салстын өөрчлөлт, шарх гарах	ЦЕШ, ШЕШ
3	Өвдөлтийн хам шинж: Хими эмчилгээнд намдахгүй бүх бие, яс үе мөч янгинаж өвдөх	-
4	Цус алдалтын шинж:	ЦЕШ, ШЕШ,
5	Саа саажилт: Хэл шүд сулрах, хиймэл шүд таарахгүй болох, ярих, залгих өөрчлөгдөх	-
6	Хаван (ерөнхий болон хэсэг газрын)	ШЕШ
7	Анафилаксын шокын үед үзүүлэх сэхээн амьдруулах тусламж (зөв байрлуулах, амьсгалыг баллон болон аппаратаар дэмжих, зүрхэнд шууд бус иллэг хийх, судсаар хийх сэхээн амьдруулах эрчимт эмчилгээ, дефебриллятор)	ЦЕШ, ШЕШ
8	Зүрх судасны дутагдлын хам шинж: зүрх дэлсэх, хэм алдах, зүрхний цохилтын тоо олшрох, цөөрөх, цусны даралт ихсэх багасах, судасны лугшилт тэмтрэгдэхгүй болох	ЭКГ, рентгеноскопи
9	Цочмог халдвар үхжлийн хам шинж: Цусны шинжилгээ, бие махбодийн өөрчлөлт, арьс, ХБЭТ-ны өөрчлөлт, элэгний үйл ажиллагаа, зүрх судасны өөрчлөлт, бөөрний үйл ажиллагаа, Бодисын солилцоо	Лаборатори, багажийн шинжилгээ

5.2.3 Зайлшгүй суралцах шаардлагатай гардан үйлдлүүд:

1. Химийн эм бэлдмэлийн харилцан үйлчлэл, фармакокинетик, фармакодинамикийг тайлбарлах, харьцангуй болон туйлын эсрэг заалтыг тодорхойлох
2. Химийн эмчилгээ хийх ерөнхий зарчим: Нэг эмээр хими эмчилгээ хийх, хавсарсан эмээр хими эмчилгээ хийх, Хорт хавдрын эсийн хөгжлийн кинетик болон эмийн дасал
3. Химийн эмчилгээний төрлүүд: Төгс хими эмчилгээ, Адьювант хими эмчилгээ, Неоадьювант хими эмчилгээ, Хөнгөвчлөх хими эмчилгээ
4. Хими эмчилгээг хийх арга замууд: Интратекаль (**Intrathecal**) болон интравентрикуляр (**Intraventricular**) эмчилгээ
5. Амаар уух, судсаар хийх, хэвлий болон цээжний хөндийд шууд хийх
6. Карновский болон ДЭМБ-ын өвчтөний биеийн байдлыг үнэлэх шалгуураар хими эмчилгээ хийлгэж байгаа өвчтөнийг үнэлэх

7. Хими эмчилгээний үед үүсэх элэгний эмгэг өөрчлөлтийн зэргийг АНУ-ын Хавдрын үндэсний институтын аргачлалаар тодорхойлох, химийн эмийн тунг бууруулах
8. Давсаг, цээж, хэвлийн хөндийд хэсэг газрын хими эмчилгээ хийх
9. Судасны гадуур хими тариа гарах үеийн авах арга хэмжээ Портын катетрын арчилгаа
10. Хорт хавдартай өвчтөн бүрт тохирсон дагнасан хими эмчилгээ болон хими, туяа хосолсон эмчилгээний менежмент (6-12 курс)
11. Хорт хавдартай өвчтөнд хийгдэх хими эмчилгээний үр дүн, гаж нөлөө, хүндрэлийг үнэлэх аргачлал (эмнэлзүй, лабораторийн шинжилгээ, хяналт)
12. Хорт хавдартай өвчтөнд хийгдэж байгаа хими эмчилгээний үед гэр бүлд түшиглэсэн тусламж үйлчилгээ үзүүлэх (эмийн гаж нөлөө, хоол, нийгмийн болон сэтгэл зүйн зөвлөгөө)
13. Хорт хавдрын мэс заслын дараах хүндрэлийг ялган таних, түүний менежмент
14. Хавдрын эсрэг өвөрмөц эмчилгээ эхлэхээс өмнөх зүрх судасны тогтолцооны үнэлгээ: Зүүн ховдлын үйл ажиллагааны алдагдал, түүний менежмент
15. Хорт хавдрын хими болон туяа эмчилгээний дараа үүсч болох бүтэц, үйл ажиллагааны алдагдлыг таних, түүний менежмент
16. Зүрхэнд эргэшгүй бүтцийн өөрчлөлт оруулдаг I бүлгийн эмүүд, түүний менежмент
17. Хуримтлагдах тунтай хамааралгүй, зүрхэнд эргэх нөлөө үзүүлдэг бэлдмэлийг моноклон эсрэг бие буюу II бүлгийн эмүүд, түүний менежмент
18. Трастузумаб болон Доксорубицин эмээс үүссэн зүрхний үйл ажиллагааны алдагдлын менежмент
19. Хавдрын эсрэг химийн эмчилгээтэй холбоотой цусны системд гарах гаж нөлөө (СТСАЕ), түүний менежмент

5.3 Хими эмчилгээний төрөлжсөн мэргэшлийн сургалтын хэлбэр

5.3.1 Ажлын байрны сургалтаар хавдрын хими эмчилгээ судлалын эмчийн зайлшгүй суралцах гардан үйлдлийг хийж гүйцэтгэхэд суралцана.

Загвар 1. Ажлын байрны сургалт (On the job training - OJT)

Аргачлал	Суралцагчийн тоо	Хугацаа	Сургалт явагдах газар	Удирдагч, хамтрагч
Амбулаторийн үзлэг хийх	2	8 цаг, долоо хоногт 1 удаа	Амбулатори	Эмнэлзүйн багш, сувилагч
Ганцаарчилсан* ба хяналтын тойрон үзлэг**	2	өдөр бүр	Химийн тасаг	Эмнэлзүйн багш, бусад эмч, сувилагч
Сургалтын тойрон үзлэг*** ба хэлэлцүүлэг	1	Сард 1 удаа, 30-60 минут	Тасаг, сургалтын	Бусад суралцагчид,

			өрөө	эмнэл зүйн сургагч багш
Бусад тасагт өвчтөн үзэх* /Хөнгөвчлөх эмчилгээ, CCRT, нео-адьювант хими эмчилгээ/	1	Шаардлагатай тохиолдол бүрт	Бусад тасаг	Эмнэл зүйн сургагч багш
Тойролтын хуваарьт заасан гардан үйлдэл хийх	4	Шаардлагатай тохиолдол бүрт	Тасаг, өдрийн хими, тарианы өрөө, боолтын өрөө	Эмнэл зүйн сургагч багш, бусад эмч, сувилагч
Олон мэргэшлийн хавдрын зөвлөгөөнд оролцох (Tumor board)	4-8	Тохиолдол байгаа үед	Хурлын болон сургалтын танхим	Тухайн тохиолдлын хавдрын эмчилгээ, менежментийг шийдэх олон мэргэшлийн эмч нар

***Өвчтөн бүрт дараах үнэлгээг нарийвчлан хийх:**

- Эмчилгээнд орох, зөвлөгөө авах, оношилгоо хийлгэх зэргээр ямар зорилгоор ирснийг сайтар тодруулах /Урьд нь эмчилгээ хийлгэж байсан эсэх, паспортын хэсэг өвчтөний овог нэр, нас хүйс, онош зэргийг шалгах/
- Өвчтөнд өвчний онош, оношилгоо, эмчилгээний арга барилыг нарийвчлан сайтар ойлгуулах
- Эмчилгээтэй холбоотой хордлого хүндрэлийг тайлбарлах, үнэлэх
- Өвчтөний ар гэрт эмчилгээний явцын асаргаа эмч-өвчтөн-ар гэрийн холбоо харилцааны ач холбогдлыг танилцуулах

****Хяналтын тойрон үзлэг:**

- Хэвтэн эмчлүүлж байгаа өвчтөний биеийн байдлыг суралцагч эмч нь эмнэл зүйн сургагч багш (бусад эмч)-д танилцуулах зорилготой үзлэг.
- Үүний тулд суралцагч эмч нь урьдчилан бие даан өвчний түүх, сувилагчийн тэмдэглэлийг үзэж танилцан, өвчтөнтэй уулзаж, асуумж цуглуулж (ганцаарчилсан үзлэг), эмнэл зүйн сургагч багш (бусад эмч)-д танилцуулахад бэлдэнэ.
- Танилцуулга хийхдээ хувь хүний мэдээллийг анхаарна. Таницуулгыг сургалтын рөө, танхим эсвэл өвчтөний өрөөнөөс гадна хийх ба өвчтөний орны дэргэдэх тойрон үзлэгийг эмнэл зүйн сургагч багш (бусад эмч)-тай хамт хийнэ. Хяналтын тойрон үзлэгээр өвчтөнөөс асуумж авах, үзлэг хийх аргад суралцана.

*****Сургалтын тойрон үзлэг:**

- Сургалтад тохиромжтой 1-2 өвчтөнийг сонгож, өвчтөний биеийн байдлыг суралцагч эмч нь танилцуулах ба бусад оролцогчид (хамтран суралцагч эмч, эмнэл зүйн сургагч багш, бусад эмч) асуулт тавьж, хэлэлцүүлэг өрнүүлнэ.

- 1 тохиолдолд 30-60 минут зарцуулна. Хэлэлцүүлгийн явцад эмнэлзүйн таамаглал дэвшүүлэх, онош тавих зэрэгт суралцана.

5.3.2. Интервеншал радиологич эмчийн танин мэдэж, суралцах шаардлагатай эмгэгүүдийн талаар онолын мэдлэг эзэмшинэ.

Загвар 2. Танхимын ба танхимын бус сургалтаар эзэмших онолын мэдлэг

Аргачлал	Суралцагч эмчийн тоо	Үргэлжлэх цаг, давтамж	Сургалт явагдах газар	Хэрэглэг-дэхүүн	Удирдагч, хамтрагч
Танхимын сургалт (Off the job training - Off JT)					
Бие даалт*	1	Чөлөөт цагаар	Сургалтын өрөө, гэртээ, номын сан	Ном, интернэт	Өөрөө, хамтран суралцагч
Лекц	10 хүртэл	7 хоногт 1-2 удаа 1 цаг	Сургалтын өрөө	Слайд, проектор, самбар	Эмнэлзүйн сургагч багш, суралцагчид
Семинар	4-8	7 хоногт 1-2 удаа 1 цаг 30 мин	Сургалтын өрөө	Слайд, проектор, самбар	Эмнэлзүйн сургагч багш, суралцагчид
Журнал клуб	4-8	Сард 1 удаа	Сургалтын өрөө	Слайд, проектор, самбар, эрдэм шинжилгээний өгүүлэл	Эмнэлзүйн сургагч багш, суралцагчид
Танхимын бус сургалтаар өөрийгөө хөгжүүлэх					
Хичээл заах	4-5 сувилагчид	1 удаа 2 цаг	Тасагт	Ном, интернет, проектор	Өөрөө, тасгийн сувилагчид
Биеийн байдал, оношилгоо, эмчилгээний талаар тайлбарлах	10 өвчтөн, тэдний гэр бүлийн гишүүд	30 минут	Тасаг, тасгийн хүлээлгийн өрөө	Өвчний түүх, карт	Өөрөө, өвчтөн, тэдний гэр бүлийнхэн
Эмгэг анатомийн конференцид оролцох	2 өвчтөн	2 удаа 4 цаг	Сургалтын тэнхим	Проектор, самбар, Өвчний түүх	Сургагч багш, бусад мэргэжлийн эмч нар

***Бие даан судлах сэдвүүд:**

- Хавдрын эрсдэлт хүчин зүйл, удамшлийн нөхцөл, үсэрхийлэл, тавилан
- Өвчтөний хяналтын хугацаанд оношлогооны нарийвчилсан шинжилгээг зөвлөх/зөвхөн хавдрын маркер, цусны шинжилгээгээр хязгаалахгүйгээр багажын шинжилгээ, дуран гм /

- Хавдрын TNM үе шатыг олон төрлийн хавдрын үед ашиглаж сурах, эмчилгээний аргууд, тэдгээрийн үр дүн, үйлдлийн механизм, заалтыг мэдсэн байх
- Хими эмчилгээ
- Гормон эмчилгээ
- Биологийн эмчилгээ
- Дархлаа эмчилгээ
- Стем эсийн трансплантаци
- Ерөнхий хими эмчилгээний үндсэн ухагдахуун, хийх аргачлал
- Хавдрын урьдчилан сэргийлэлт ба эрт илрүүлэг
- Паранеопластик синдромууд
- Хими эмчилгээний гаж нөлөөний үед яаралтай тусламж үзүүлэх
- Дархлаа дарангуйлагдсан өвчтөнүүд, жирэмсэн эмэгтэй, өндөр настай өвчтөнүүд, өсвөр насныхан гэх мэт тусгай бүлгийн өвчтөнүүдэд менежмент хийх
- Эмчилгээний явцад илэрсэн хурц, урт хугацааны болон хожуу илрэх гаж нөлөөнүүд
- Хавдрыг даван туулсан өвчтөнүүдийн бие махбодиос гадна сэтгэл зүй, нийгэм, амьдралын хэв маяг, сексийн амьдрал, үргүйдэл зэрэг асуудлыг уншиж судлах

5.4 Сургалтын төгсгөлд эзэмшсэн байх чадвар:

- Хавдрын хими эмчилгээний гардан хийх үйлдлүүдийг бие даан хийх ур чадвар эзэмших, өвчтөний түүх бичих онцлогт суралцах
- Хими эмчилгээ хийх заалт, гарч болох хүндрэл, үр дүнд үнэлгээ өгөх, өвчтөн, түүний гэр бүлийнхэнд зөвлөгөө өгөх ур чадвар эзэмших
- Тархи, толгой хүзүүний байрлалын хорт хавдар, арьс, зөөлөн эдийн хорт хавдар, яс, уушигны хорт хавдар, хоол боловсруулах замын хорт хавдар, элэг цөс, нойр булчирхайн хорт хавдар, бөөр, давсаг, хэвлийн гялтан хальсны хорт хавдар, мэдрэл, дотоод шүүрлийн булчирхайн хорт хавдар, эмэгтэйчүүд болон эрэгтэйчүүдийн байрлалын хорт хавдар, анхдагч тодорхойгүй хавдрын ялган оношилгоо, хими эмчилгээний асуудлаар санал дэвшүүлэх, зөвлөлдөх ур чадвар эзэмших
- Шаардлагатай тохиолдолд сэхээн амьдруулах тусламжийг цаг алдалгүй үзүүлэх эсвэл зохих шатны мэргэжлийн газарт илгээх чадвар эзэмших
- Эмнэлзүйн тохиолдлын танилцуулга бэлтгэж танилцуулах, хэлэлцүүлэг хийх чадвар эзэмших
- Өөрөө бие даан шинжлэх ухааны үндэслэлтэй академик мэдлэг олж авах, өөрийн эзэмшсэн чиглэлээр сургалт явуулах чадвар эзэмшсэн, нотолгоонд тулгуурласан эрдэм шинжилгээний илтгэл өгүүлэл бичих, түүнийгээ илтгэх ур чадварт суралцах

**ЗУРГАА. “ХАВДРЫН ХИМИ ЭМЧИЛГЭЭ СУДЛАЛ”
ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН СУРГАЛТЫН ТОЙРОЛТ**

Хорт хавдартай үйлчлүүлэгчид хими эмчилгээ хийх, яаралтай тусламж үзүүлэхэд туслахаар оролцох, эмчийн зөвшөөрлөөр түүний хяналтын дор 19 гардан үйлдлийг хийж гүйцэтгэнэ. Зайлшгүй суралцах эмгэгийн тохиолдлоос хамаарч нийтлэг тохиолдолд 20-иос доошгүй, ховор тохиолдолд 10-аас доошгүй удаа хийж гүйцэтгэнэ.

Загвар 3. Сургалтын тойролтын хуваарь

Тойролтын нэр	Хугацаа	Байршил
Тойролт 1. Баримжаа олгох хөтөлбөр	8 цаг	ХСҮТ-ийн НЭМТСА, ХНХА, ХХБТЭИА, ХХСА
Тойролт 2. Хоол боловсруулах эрхтэн тогтолцооны хавдруудын хими эмчилгээ	6 долоо хоног	ХСҮТ-ийн ЭМЗТ, Дурангийн тасаг, Хими ЭТ
Тойролт 3. Хөхний хорт хавдар, хөхний үсэрхийлсэн хавдруудын хими эмчилгээ	6 долоо хоног	ХСҮТ-ийн Хөхний төв, ДОТ, Хими ЭТ
Тойролт 4. Уушгины хорт хавдар, уушгины үсэрхийлсэн хавдруудын хими эмчилгээ	6 долоо хоног	ХСҮТ-ийн ЦХМЗТ, ДОТ, ТЭТ, Хими ЭТ
Тойролт 5. Эмэгтэйчүүдийн байрлалын эрхтэний хавдруудын хими эмчилгээ	7 долоо хоног	ХСҮТ-ийн ЭМЗТ, ТЭТ, Хими ЭТ
Тойролт 6. Яс, зөөлөн эд, арсны хавдруудын хими эмчилгээ	4 долоо хоног	ХСҮТ-ийн ЭМЗТ, Хими ЭТ
Тойролт 7. Элэг цөс, нойр булчирхайн хавдруудын хими эмчилгээ	5 долоо хоног	ХСҮТ-ийн ЭЦНБМЗТ, Хими ЭТ
Тойролт 8. Эрэгтэйчүүдийн байрлалын хавдруудын хими эмчилгээ	4 долоо хоног	ХСҮТ-ийн ЭМЗТ, Хими ЭТ
Тойролт 9. Толгой хүзүүний байрлалын хорт хавдруудын хими эмчилгээ	4 долоо хоног	ХСҮТ-ийн ТХМЗТ, ТЭТ, Хими ЭТ
Тойролт 10. Анхдагч байрлалын хорт хавдруудын хими эмчилгээ	2 долоо хоног	ХСҮТ-ийн Хими ЭТ
Нийт	44 долоо хоног	

Тойролт тус бүрийн үйл ажиллагааг дараах хуваариар зохион байгуулна.

Загвар 4. Үйл ажиллагааны хуваарь

	08:00 –08:30	08:30 – 09:00	09:00 – 13:00	13:30 – 15:00
Даваа	Ганцаарчилсан үзлэг	Хяналтын тойрон үзлэг	Химийн эмчилгээнд оролцох, түүх нээх, хаах	Лекц, семинар
Мягмар	Ганцаарчилсан үзлэг	Эмч нарын яриа	Химийн эмчилгээнд оролцох, түүх нээх, хаах	
Лхагва	Ганцаарчилсан үзлэг	Амбулаторийн үзлэг		
Пүрэв	Ганцаарчилсан үзлэг	Хяналтын тойрон үзлэг	Химийн эмчилгээнд оролцох, түүх нээх, хаах	Лекц Семинар
Баасан	Ганцаарчилсан үзлэг	Хяналтын тойрон үзлэг	Эмчилгээний хяналт	Журнал клуб

ТОЙРОЛТ-1. БАРИМЖАА ОЛГОХ ХӨТӨЛБӨР

Агуулга:

- ХСҮТ-ийн дотоод журам, ёс зүйн хэм хэмжээ болон бусад холбогдох хууль эрх зүйн бичиг баримтуудыг судлах,
- ХСҮТ-ийн тасгуудын үйл ажиллагаа болон СҮАЗ-тай танилцах
- Байгууллагын цахим программуудын ажиллах зарчмыг судлах, дадлагажих
- Халдварын хяналт, сэргийлэлтийн ерөнхий зарчим, эрүүл мэндийн ажилтны дархлаажуулалт, хувийн хамгаалах хувцас хэрэгсэл, ажлын байрны осол гэмтлийн үеийн менежментийг судлах
- Сургалтын гэрээ байгуулах

ТОЙРОЛТ 2. ХООЛ БОЛОВСРУУЛАХ ЭРХТЭН ТОГТОЛЦООНЫ ХАВДРУУДЫН ХИМИ ЭМЧИЛГЭЭ

Оношийн код: C15, C16, C17, C18, C20

Хугацаа: Найман долоо хоног

Агуулга:

- Хоол боловсруулах эрхтэн системийн хавдруудын ерөнхий ойлголт.
- Хоол боловсруулах эрхтэн системийн хавдруудын эпидемиологи. шалтгаант хүчин зүйл, патоморфологийн ангилал
- Хоол боловсруулах эрхтэн системийн хавдруудын тунгалагийн булчирхай руу үсэрхийлэл өгөх механизм
- Хоол боловсруулах эрхтэн системийн эмнэл зүйн шинж тэмдэг, хэт авиан болон багажийн шинжилгээг үнэлэх (хэт авиан шинжилгээ, компьютерт томограф, соронзон хэлбэлзлийн багажийн шинжилгээ)
- Хоол боловсруулах эрхтэн системийн хими эмчилгээний ерөнхий зарчим, эмийн сонголт хийх, эмийн мэдрэг байдлыг тогтоох, эмчилгээний төлөвлөгөө гаргах
- Хоол боловсруулах эрхтэн системийн хими эмчилгээний эсрэг заалт, гаж нөлөө, хүндрэлийг тодорхойлох, тэдгээрийн эмчилгээ
- Туяа эмчилгээтэй хавсран хийх химийн эмчилгээний онцлог, үр дүн, зарчим
- Адьювант эмчилгээний онцлог үр дүн
- Неадьювант эмчилгээний онцлог үр дүн
- Хөнгөвчлөх эмчилгээний онцлог үр дүн
- Химийн эмчилгээний үед гарах лабораторийн шинжилгээнд гарах өөрчлөлт, авах арга хэмжээ
- Химийн эмчилгээний үр дүнг үнэлэх, эмчилгээг зогсоох, эмийн тунг бууруулах дараагийн эгнээний эмийг сонгох, хяналт

Зайлшгүй суралцах гардан үйлдэл, мэс ажилбар (15-аас доошгүй)

Гардан үйлдэл	Тоо	Үүрэг
I Ходоод, улаан хоолой, бүдүүн, шулуун гэдэсний хавдар		

1. Үйлчлүүлэгчийн асуумж, үзлэг, дүрс оношилгоо, эдийн шинжилгээнд дүгнэлт хийх	20	Бие дааж хийх
2 Эмгэгтэй үйлчлүүлэгчийн биеийн гадаргууг тодорхойлон эмийн тунг тогтоох	15	Бие дааж хийх
3 Зөөлөн эд,арьсны эмгэгтэй үйлчлүүлэгчийн химийн эмчилгээний төлөвлөгөө гаргах	20	Бие дааж хийх, туслах эмчийн үүрэг гүйцэтгэх
II Алсад үсэрхийлсэн болон дахисан хавдар		
1. Алсад үсэрхийлсэн, дахисан хавдартай үйлчлүүлэгчийн асуумж, үзлэг, дүрс оношилгоо, эдийн шинжилгээнд дүгнэлт хийх	20	Бие дааж хийх
2. Бусад эмчилгээтэй хавсран хийх химийн эмчилгээтэй өвчтөн үзэх	10	
3. Өвчтөнд зөвлөгөө өгөх, хяналт хийх	20	

ТОЙРОЛТ-3. ХӨХНИЙ ХОРТ ХАВДАР, ХӨХНИЙ ҮСЭРХИЙЛСЭН ХАВДРУУДЫН ХИМИ ЭМЧИЛГЭЭ

Оношийн код: D05; D05.0-D05.9; D24; C50; C50.0-C50.9;

Хугацаа: Зургаан долоо хоног

Тойролтын агуулга:

- Хөхний хорт хавдрын ерөнхий ойлголт, хөхний бүтэц, анатоми
- Хөхний хорт хавдрын эпидемиологи, хөхний хорт хавдрын шалтгаан хүчин зүйл, эмгэг морфологийн ангилал
- Хөхний хорт хавдрын эмнэл зүйн шинж тэмдэг, нэмэлт оношилгооны аргууд (хэт авиан шинжилгээ, маммографи, компьютер томографи, соронзон хэлбэлзлийн багажийн шинжилгээ, эс, эдийн шинжилгээ)
- Хөхний хортой хавдрын хими эмчилгээ, хяналт
- Хөхний хорт хавдрын хими эмчилгээний дараах хүндрэлийг үнэлэх, түүний менежмент
- Хими эмчилгээний дараах хяналт, зөвлөгөө

ТОЙРОЛТ-4. УУШГИНЫ ХОРТ ХАВДАР, УУШГИНЫ ҮСЭРХИЙЛСЭН ХАВДРУУДЫН ХИМИ ЭМЧИЛГЭЭ

Оношийн код: D15; D15.0-D15.9; C34; C34.0-C34.9

Хугацаа: Зургаан долоо хоног

Тойролтын агуулга:

- Уушгины хорт хавдрын ерөнхий ойлголт, уушгины бүтэц, анатоми
- Уушгины хорт хавдрын эпидемиологи, уушгины хорт хавдрын шалтгаан хүчин зүйл, эмгэг морфологийн ангилал

- Уушгины хорт хавдрын эмнэл зүйн шинж тэмдэг, нэмэлт оношилгооны аргууд (бронхоскопи, компьютер томографи, соронзон хэлбэлзлийн багажийн шинжилгээ, эс, эдийн шинжилгээ)
- Уушгины хортой хавдрын хими эмчилгээ, хяналт
- Уушгины хорт хавдрын хими эмчилгээний дараах хүндрэл, түүнийг үнэлэх
- Хими эмчилгээний дараах хяналт, зөвлөгөө

Зайлшгүй суралцах гардан үйлдэл, мэс ажилбар (15-аас доошгүй)

Гардан үйлдэл	Тоо	Үүрэг
I.Хөхний хорт хавдар		
1. Хөхний хорт хавдартай үйлчлүүлэгчийн асуумж, үзлэг, шинжилгээ, дүрст оношилгооны дүгнэлтэнд анализ хийж, өвчтөний түүх нээх	20	Бие дааж хийх
2. Хөхний хорт хавдартай өвчтөний химийн эмчилгээг шивж оруулах	20	Бие дааж хийх
3. Шаардлагатай үзлэг, шинжилгээг төлөвлөн бусад эмч нартайгаа хамтран ажиллах	15	Бие дааж хийх
4. Хими эмчилгээний үед гарах гаж нөлөө, хүндрэлийг үнэлж, эмчлэх	20	Бие дааж хийх
II. Уушгины хорт хавдар		
1. Уушгины хорт хавдартай үйлчлүүлэгчийн асуумж, үзлэг, шинжилгээ, дүрст оношилгооны дүгнэлтэнд анализ хийж, өвчтөний түүх нээх	20	Бие дааж хийх
2. Уушгины хорт хавдартай өвчтөний химийн эмчилгээг шивж оруулах	20	Бие дааж хийх
3. Шаардлагатай үзлэг, шинжилгээг төлөвлөн бусад эмч нартайгаа хамтран ажиллах	15	Бие дааж хийх
4. Хими эмчилгээний үед гарах гаж нөлөө, хүндрэлийг үнэлж, эмчлэх	20	Бие дааж хийх

ТОЙРОЛТ-5. ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН БАЙРЛАЛЫН ХАВДРУУДЫН ХИМИ ЭМЧИЛГЭЭ

Оношийн код: C54, C53, C56,

Хугацаа: Дөрвөн долоо хоног

Тойролтын агуулга:

- Умайн их бие, умайн хүзүүний болон өндгөвчний хавдрын ерөнхий ойлголт
- Умайн их бие, умайн хүзүүний болон өндгөвчний хавдрын эпидемиологи, хавдрын шалтгаант хүчин зүйл, эмгэг морфологийн ангилал
- Умайн их бие, умайн хүзүүний болон өндгөвчний хавдрын эмнэл зүйн шинж тэмдэг, хэт авиан болон багажийн шинжилгээг үнэлэх (хэт авиан шинжилгээ, компьютерт томограф, соронзон хэлбэлзлийн багажийн шинжилгээ)

- Умайн их бие, умайн хүзүүний болон өндгөвчний хавдрын хими эмчилгээний ерөнхий зарчим, эмийн сонголт хийх, эмийн мэдрэг байдлыг тогтоох, эмчилгээний төлөвлөгөө
- Умайн их бие, умайн хүзүүний болон өндгөвчний хавдрын хими эмчилгээний эсрэг заалт, гаж нөлөө, хүндрэлийг тодорхойлох, тэдгээрийн эмчилгээ
- Умайн их бие, умайн хүзүүний болон өндгөвчний хавдар тунгалагийн булчирхай руу үсэрхийлэл өгөх механизм
- Туяа эмчилгээтэй хавсран хийх химийн эмчилгээний онцлог, үр дүн, зарчим
- Адьювант эмчилгээний онцлог үр дүн
- Неадьювант эмчилгээний онцлог үр дүн
- Хөнгөвчлөх эмчилгээний онцлог үр дүн
- Химийн эмчилгээний үед гарах лабораторийн шинжилгээнд гарах өөрчлөлт, авах арга хэмжээ
- Химийн эмчилгээний үр дүнг үнэлэх, эмчилгээг зогсоох, эмийн тунг бууруулах дараагийн эгнээний эмийг сонгох, хяналт

Зайлшгүй суралцах гардан үйлдэл, мэс ажилбар (Нийтлэг тохиолддог бол 20, ховор тохиолддог бол 5-аас доошгүй)

Гардан үйлдэл	Тоо	Үүрэг
I Умайн их бие, умайн хүзүүний болон өндгөвчний хавдар		
1. Умайн их биеийн эмгэгтэй үйлчлүүлэгчийн асуумж, үзлэг, дүрс оношилгоо, эдийн шинжилгээнд дүгнэлт хийх	20	Бие дааж хийх
2. Умайн их биеийн эмгэгтэй үйлчлүүлэгчийн биеийн гадаргууг тодорхойлон эмийн тунг тогтоох	15	Бие дааж хийх
3. Умайн их биеийн эмгэгтэй үйлчлүүлэгчийн химийн эмчилгээний төлөвлөгөө гаргах	20	Бие дааж хийх, туслах эмчийн үүрэг гүйцэтгэх
II Умайн их бие, умайн хүзүүний болон өндгөвчний үсэрхийлсэн болон дахисан хавдар		
2. Үсэрхийлсэн, дахисан хавдартай үйлчлүүлэгчийн асуумж, үзлэг, дүрс оношилгоо, эдийн шинжилгээнд дүгнэлт хийх	20	Бие дааж хийх
3. Туяа эмчилгээтэй хавсран хийх химийн эмчилгээтэй өвчтөн үзэх	10	
4. Өвчтөнд зөвлөгөө өгөх, хяналт хийх	20	

ТОЙРОЛТ-6. ЯС, ЗӨӨЛӨН ЭД, АРСНЫ ХАВДРУУДЫН ХИМИ ЭМЧИЛГЭЭ

Оношийн код: C40, C41, C42, C43, C44, C45, C49, C43, C44

Хугацаа: Дөрвөн долоо хоног

Тойролтын агуулга:

- Яс, зөөлөн эд, арьсны хавдруудын ерөнхий ойлголт

- Яс, зөөлөн эд, арьсны хавдруудын эпидемиологи, хавдрын шалтгаант хүчин зүйл, эмгэг морфологийн ангилал
- Яс, зөөлөн эд, арьсны хавдруудын эмнэл зүйн шинж тэмдэг, хэт авиан болон багажийн шинжилгээг үнэлэх (хэт авиан шинжилгээ, компьютерт томограф, соронзон хэлбэлзлийн багажийн шинжилгээ)
- Яс, зөөлөн эд, арьсны хавдруудын хими эмчилгээний ерөнхий зарчим, эмийн сонголт хийх, эмийн мэдрэг байдлыг тогтоох, эмчилгээний төлөвлөгөө гаргах
 - Яс, зөөлөн эд, арьсны хавдруудын хими эмчилгээний эсрэг заалт, гаж нөлөө, хүндрэлийг тодорхойлох, тэдгээрийн эмчилгээ
 - Яс, зөөлөн эд, арьсны хавдруудын тунгалагийн булчирхай руу үсэрхийлэл өгөх механизм
 - Туяа эмчилгээтэй хавсран хийх химийн эмчилгээний онцлог, үр дүн, зарчим
 - Адьювант эмчилгээний онцлог үр дүн
 - Неадьювант эмчилгээний онцлог үр дүн
 - Хөнгөвчлөх эмчилгээний онцлог үр дүн
 - Химийн эмчилгээний үед гарах лабораторийн шинжилгээнд гарах өөрчлөлт, авах арга хэмжээ
 - Химийн эмчилгээний үр дүнг үнэлэх, эмчилгээг зогсоох, эмийн тунг бууруулах дараагийн эгнээний эмийг сонгох, хяналт

Зайлшгүй суралцах гардан үйлдэл, мэс ажилбар (15-аас доошгүй)

Гардан үйлдэл	Тоо	Үүрэг
I Яс, зөөлөн эд, арьсны хавдар		
1. Ясны, зөөлөн эд, арьсны эмгэгтэй үйлчлүүлэгчийн асуумж, үзлэг, дүрс оношилгоо, эдийн шинжилгээнд дүгнэлт хийх	20	Бие дааж хийх
2. Яс, зөөлөн эд, арьсны эмгэгтэй үйлчлүүлэгчийн биеийн гадаргууг тодорхойлон эмийн тунг тогтоох	15	Бие дааж хийх
3. Яс, зөөлөн эд, арьсны эмгэгтэй үйлчлүүлэгчийн химийн эмчилгээний төлөвлөгөө гаргах	20	Бие дааж хийх, туслах эмчийн үүрэг гүйцэтгэх
II Яс, зөөлөн эд, арьсны үсэрхийлсэн болон дахисан хавдар		
4. Үсэрхийлсэн, дахисан хавдартай үйлчлүүлэгчийн асуумж, үзлэг, дүрс оношилгоо, эдийн шинжилгээнд дүгнэлт хийх	20	Бие дааж хийх
5. Туяа эмчилгээтэй хавсран хийх химийн эмчилгээтэй өвчтөн үзэх	10	
6. Өвчтөнд зөвлөгөө, хяналт	20	

ТОЙРОЛТ-7. ЭЛЭГ ЦӨС, НОЙР БУЛЧИРХАЙН ХАВДРУУДЫН ХИМИ ЭМЧИЛГЭЭ

Оношийн код: C22, C22,1, C25

Хугацаа: Дөрвөн долоо хоног

Тойролтын агуулга:

- Элэг цес, нойр булчирхайн хавдрын ерөнхий ойлголт
- Элэг цес, нойр булчирхайн хавдрын эпидемиологи, шалтгаант хүчин зүйл, эмгэг морфологийн ангилал
- Элэг цес, нойр булчирхайн хавдрын эмнэл зүйн шинж тэмдэг, хэт авиан болон багажийн шинжилгээг үнэлэх (хэт авиан шинжилгээ, компьютерт томограф, соронзон хэлбэлзлийн багажийн шинжилгээ)
- Элэг цес, нойр булчирхайн хавдрын хими эмчилгээний ерөнхий зарчим, эмийн сонголт хийх, эмийн мэдрэг байдлыг тогтоох, эмчилгээний төлөвлөгөө гаргах
- Элэг цес, нойр булчирхайн хавдрын хими эмчилгээний эсрэг заалт, гаж нөлөө, хүндрэлийг тодорхойлох, тэдгээрийн эмчилгээ
- Элэг цес, нойр булчирхайн хавдар тунгалагийн булчирхай руу үсэрхийлэл өгөх механизм
- Туяа эмчилгээтэй хавсран хийх химийн эмчилгээний онцлог, үр дүн, зарчим
- Адьювант хими эмчилгээний онцлог үр дүн
- Неадьювант хими эмчилгээний онцлог үр дүн
- Хөнгөвчлөх хими эмчилгээний онцлог үр дүн
- Химийн эмчилгээний үед гарах лабораторийн шинжилгээнд гарах өөрчлөлт, авах арга хэмжээ
- Химийн эмчилгээний үр дүнг үнэлэх, эмчилгээг зогсоох, эмийн тунг бууруулах дараагийн эгнээний эмийг сонгох, хяналт

Зайлшгүй суралцах гардан үйлдэл, мэс ажилбар (15-аас доошгүй)

Гардан үйлдэл	Тоо	Үүрэг
I Элэг цес, нойр булчирхайн хавдар		
1. Элэгний хавдартай үйлчлүүлэгчийн асуумж, үзлэг, дүрс оношилгоо, эдийн шинжилгээнд дүгнэлт хийх	20	Бие дааж хийх
2. Элэгний хавдартай үйлчлүүлэгчийн биеийн гадаргууг тодорхойлон эмийн тунг тогтоох	15	Бие дааж хийх
3. Элэгний хавдартай үйлчлүүлэгчийн химийн эмчилгээний төлөвлөгөө гаргах	20	Бие дааж хийх, туслах эмчийн үүрэг гүйцэтгэх
II Элэг цес, нойр булчирхайн үсэрхийлсэн болон дахисан хавдар		
4. Үсэрхийлсэн, дахисан хавдартай үйлчлүүлэгчийн асуумж, үзлэг, дүрс оношилгоо, эдийн шинжилгээнд дүгнэлт хийх	20	Бие дааж хийх
5. Туяа эмчилгээтэй хавсран хийх химийн эмчилгээтэй өвчтөн үзэх	10	
6. Өвчтөнд зөвлөгөө өгөх, хяналт хийх	20	

ТОЙРОЛТ-8. ЭРЭГТЭЙЧҮҮДИЙН БАЙРЛАЛЫН ХАВДРУУДЫН ХИМИ ЭМЧИЛГЭЭ

Оношийн код: C60, C62, C63, C61

Хугацаа: Дөрвөн долоо хоног

Тойролтын агуулга:

1. Түрүү булчирхайн, шодой, төмсөгний хавдруудын ерөнхий ойлголт
2. Түрүү булчирхайн, шодой, төмсөгний хавдруудын эпидемиологи, шалтгаант хүчин зүйл, патоморфологийн ангилал
3. Түрүү булчирхайн, шодой, төмсөгний хавдруудын эмнэл зүйн шинж тэмдэг, хэт авиан болон багажийн шинжилгээг үнэлэх (хэт авиан шинжилгээ, компьютерт томограф, соронзон хэлбэлзлийн багажийн шинжилгээ)
4. Түрүү булчирхайн, шодой, төмсөгний хавдруудын хими эмчилгээний ерөнхий зарчим, эмийн сонголт хийх, эмийн мэдрэг байдлыг тогтоох, эмчилгээний төлөвлөгөө гаргах
5. Түрүү булчирхайн, шодой, төмсөгний хавдруудын хими эмчилгээний эсрэг заалт, гаж нөлөө, хүндрэлийг тодорхойлох, тэдгээрийн эмчилгээ
6. Түрүү булчирхайн, шодой, төмсөгний хавдруудын тунгалагийн булчирхай руу үсэрхийлэл өгөх механизм
7. Туяа эмчилгээтэй хавсран хийх химийн эмчилгээний онцлог, үр дүн, зарчим
8. Адьювант хими эмчилгээний онцлог үр дүн
9. Неoadьювант хими эмчилгээний онцлог үр дүн
10. Хөнгөвчлөх хими эмчилгээний онцлог үр дүн
11. Химийн эмчилгээний үед гарах лабораторийн шинжилгээнд гарах өөрчлөлт, авах арга хэмжээ
12. Химийн эмчилгээний үр дүнг үнэлэх, эмчилгээг зогсоох, эмийн тунг бууруулах дараагийн эгнээний эмийг сонгох, хяналт

Зайлшгүй суралцах гардан үйлдэл, мэс ажилбар (15-аас доошгүй)

Гардан үйлдэл	Тоо	Үүрэг
Түрүү булчирхай, шодой, төмсөгний хавдар		
1 Түрүү булчирхай, шодой, төмсөгний хавдартай үйлчлүүлэгчийн асуумж, үзлэг, дүрс оношилгоо, эдийн шинжилгээнд дүгнэлт хийх	20	Бие дааж хийх
2 Түрүү булчирхай, шодой, төмсөгний хавдартай үйлчлүүлэгчийн биеийн гадаргууг тодорхойлон эмийн тунг тогтоох	15	Бие дааж хийх
3 Түрүү булчирхай, шодой, төмсөгний хавдартай үйлчлүүлэгчийн химийн эмчилгээний төлөвлөгөө гаргах	20	Бие дааж хийх, туслах эмчийн үүрэг гүйцэтгэх
II Түрүү булчирхай, шодой, төмсөгний үсэрхийлсэн болон дахисан хавдар		
1 Түрүү булчирхайн үсэрхийлсэн, дахисан хавдартай үйлчлүүлэгчийн асуумж, үзлэг, дүрс оношилгоо, эдийн шинжилгээнд дүгнэлт хийх	20	Бие дааж хийх
2 Туяа эмчилгээтэй хавсран хийх химийн эмчилгээтэй өвчтөн үзэх	10	
3 Өвчтөнд зөвлөгөө өгөх, хяналт хийх	20	

ТОЙРОЛТ-9. ТОЛГОЙ ХҮЗҮҮНИЙ БАЙРЛАЛТАЙ ХАВДРУУДЫН ХИМИ ЭМЧИЛГЭЭ

Оношийн код: Бамбай булчирхай өмөн, Шүлсний булчирхайн өмөн, Хүзүүний анхдагч ба хоёрдогч өмөн, Эрүүний ясны анхдагч ба хоёрдогч өмөн, Хамар, хамрын дайврын өмөн, Амны хөндийн өмөн, Залгиур, төвөнхийн өмөн

Хугацаа: Дөрвөн долоо хоног

Тойролтын агуулга:

- ТХБХ-ын ерөнхий ойлголт, эпидемиологи, хавдрын шалтгаан хүчин зүйл, эмгэг морфологийн ангилал, эмнэл зүйн шинж тэмдгүүд оношилгоо эмчилгээний зарчим ТХБХ-ын үеийн эд эсийн шинжилгээний хэлбэр, хавдрын үе шатыг тогтоох өвчтнийг үнэлэх, химийн эмчилгээ хавсран хийх эмчилгээ болон эмчилгээний эсрэг заалт гарч өолох хүндрэл эрсдлийг тодорхойлох эмчилгээний арга хэлбэрийг сонгох
- 2 ТХБХ-ын үеийн химийн эмчилгээний ерөнхий зарчим эмийн сонголт хийх эмийн мэдрэг байдлыг тогтоох эмчилгээний төлөвлөгөө гаргах
- 3 ТХБХ-ын үеийн химийн бай дархлаа эмчилгээний үед гарах хүндрэл эрсдлийн үед авах арга хэмжээ эмчилгээний онцлог байдал авах арга хэмжээ эмчилгээг зогсоох дараагийн эгнээний бэлдмэлийг сонгох эмчилгээний зорилго зорилтыг тодорхойлох оношлогоо эмчилгээ .
- 4 Хүзүүний тунгалагийн булчирхайд үсэрхийлсэн хавдрын химийн эмчилгээний зарчмууд
- 5 Анхдагч хавдар тодорхойгүй хүзүүний тунгалагийн булчирхай дахь үсэрхийллийн химийн болон бай дархлаа эмчилгээний зарчмууд.
- 6 ТХБХ-ын үеийн бай болон биологийн эмчилгээ
- 7 ТХБХ-ын үеийн дархлаа эмчилгээ
- 8 Туяа эмчилгээтэй хавсран хийх химийн эмчилгээний онцлог үр дүн зарчим
- 9 ТХБХ-ын дахилтын үеийн химийн бай дархлаа эмчилгээ.
- 10 Адьювант эмчилгээний онцлог үр дүн
- 11 Неадьювант эмчилгээний онцлог үр дүн
- 12 Хөнгөвчлөх эмчилгээний онцлог үр дүн
- 13 ТХБХ-ын химийн эмчилгээний үед гарах цус биохимийн шинжилгээний өөрчлөлт авах арга хэмжээ
- 14 ТХБХ-ын химийн эмчилгээний үеийн хоололт амны хөндийн арчилгаа.
- 15 ТХБХ-ын үеийн химийн эмчилгээг зогсоох, эмийн тунг бууруулах дараагийн эгнээний эмийг сонгох хяналт тавих.

Зайлшгүй суралцах гардан үйлдэл, мэс ажилбар (15-аас доошгүй)

Бие даалт	Тоо	Үүрэг
Заавал биелүүлэх үзүүлэлт.		
1. Бамбай булчирхайн өмөнтэй үйлчлүүлэгчийн асуумж, үзлэг, эдийн болон дүрст оношилгооны дүгнэлтийн анализ хийх эмчилгээний эмийг сонгох биеийн гадаргууг тодорхойлон эмийн тунг тогтоох.		Бие дааж хийх
2. Шүлсний булчирхайн өмөнгийн эдийн болон	5	Бие дааж хийх

бусад шинжилгээ мэс заслын дүгнэлтэнд үнэлгээ хийж биеийн гадаргууг тооцон эмийн тунг тогтоох		
3. Төвөнхийн хавдрын мэс заслын дүгнэлт эдийн болон бусад шинжилгээнд дүгнэлт хийн химийн эмчилгээний төлөвлөгөө гаргах	5	Туслах эмчийн үүрэг гүйцэтгэх
II Хүзүүний тунгалгийн булчирхайн эмгэг		
4. Хамрын болон хамрын дайврын хавдартай үйлчлүүлэгчийн асуумж, үзлэг, дүрст оношилгооны мэс заслын дараах шинжилгээнд дүгнэлт хийх химийн эмчилгээний төлөвлөгөө гаргах.	10	Бие дааж хийх Туслах эмчийн үүрэг гүйцэтгэх
5. Туяа эмчилгээтэй хавсран хийх химийн эмчилгээтэй өвчтөн үзэх	5	
6. Үсэрхийлсэн хавдрын үеийн эмчилгээтэй өвчтөн үзэх	5	
III Хүзүүний зөөлөн эдийн бусад хавдар		
7. Хүзүүний зөөлөн эдийн хавдартай үйлчлүүлэгчийн асуумж, үзлэг, мэс заслын болон дүрст оношилгооны шинжилгээнд дүгнэлт хийх эмчилгээний эм сонгох тун тогтоох	2	Бие дааж хийх
8. Эрүүний ясны өмөнтэй өвчтөн үзэх химийн эмчилгээ хийх	2	Бие дааж хийх, туслах эмчийн үүрэг гүйцэтгэх
9. Ам залгиур хэлний хавдартай өвчтөн үзэх химийн эмчилгээ хийх	5	Туслах эмчийн үүрэг гүйцэтгэх

ТОЙРОЛТ-10. АНХДАГЧ ТОДОРХОЙГҮЙ ХАВДРУУДЫН ХИМИ ЭМЧИЛГЭЭ

Оношийн код: С80

Хугацаа: Дөрвөн долоо хоног

Тойролтын агуулга:

- Анхдагч тодорхойгүй хавдруудын тухай ерөнхий ойлголт
- Анхдагч тодорхойгүй хавдрын тархалт, шалтгаан, хүчин зүйлс
- Анхдагч тодорхойгүй хавдрууд түүний ангилал, эмнэл зүй, ялган оношилгоо
- Анхдагч тодорхойгүй хавдруудын хими эмчилгээний сонголт, тун хэмжээг тооцох
- Анхдагч тодорхойгүй хавдруудын хими эмчилгээний эмчилгээний хяналт, хүндрэлээс сэргийлэх

Зайлшгүй суралцах гардан үйлдэл, мэс ажилбар (15-аас доошгүй)

Гардан үйлдэл, мэс засал	Тоо	Үүрэг
1. Анхдагч тодохройгүй хавдартай үйлчлүүлэгчид асуумж, үзлэг, шинжилгээ, дүрст оношилгооны дүгнэлтийн анализ хийх	20	Бие дааж хийх
2. Анхдагч тодорхойгүй хавдартай үйлчлүүлэгчид хими эмчилгээ төлөвлөж, тунг тооцох	20	Бие дааж хийх

3. Анхдагч тодорхойгүй хавдартай үйлчлүүлэгчид хими эмчилгээнд хяналт тавих	20	Бие дааж хийх
4. Анхдагч тодорхойгүй хавдартай үйлчлүүлэгчид хими эмчилгээнд хүндрэлийн үед арга хэмжээ авах	20	Бие дааж хийх

ДОЛОО. ҮНЭЛГЭЭ, ЭРГЭН ЗӨВЛӨГӨӨ

7.1. Суралцагч эмч ба хариуцагч (mentor)

Суралцагч эмч бүрт сургалтын нэг жилийн хугацаанд хариуцагч эмч (mentor)-ийг тасгийн эрхлэгч хуваарилж өгнө. Хариуцагч эмч (mentor) нь хариуцсан суралцагч эмчийн хувийн төлөвлөгөөний (career plan) талаар зөвлөлдөх, хэрхэн ахин дэвшиж байгаа болон юунд анхаарах, хэрхэн сайжрахыг эргэн зөвлөнө. Суралцагч эмч нь сургалт эхлэх үед хариуцагч эмчтэй уулзах ба цаашид 2-3 сар буюу тойролт бүрийн дараа уулзаж ярилцан, үнэлгээтэй танилцаж эргэн зөвлөгөө авна.

7.2. Суралцагч эмч ба эмнэл зүйн сургагч багш

Суралцагч эмчийн тойролт бүрийг эмнэл зүйн сургагч багш удирдана. Тойролт удирдах эмнэлзүйн сургагч багшийг тасгийн эрхлэгч суралцагч бүрт оноож өгнө.

- Суралцагч нь тойролт бүрийн эхэнд сургагч багштай уулзан тойролтын хуваарьтай танилцан тухайн тойролтод сурч эзэмшихээр зорьсон зорилтоо ярилцана.
- Тойролтын явцад зорилтондоо хүрэхэд дутагдаж байгаа болон нөхөх хэрэгцээтэй байгаа зүйлсээ ярилцана.
- Суралцагч эмч нь тойролт дуусахад эмнэл зүйн сургагч багштай ярилцлага хийж, сургалттай холбоотой асуудлаар заавар, зөвлөгөө авна.

7.3 Үнэлгээний арга, төлөвлөгөө

Үнэлгээг дараах төлөвлөгөөний дагуу үнэлгээний аргаас хамааран эмнэл зүйн сургагч багш, тасгийн бусад эмч, сувилагч, өвчтөн, сургалтын албаны ажилтан, шалгалтын комисс хуваарийн дагуу хийнэ. Явцын үнэлгээний дүнг суралцагч эмчээс гадна сургалтын алба хадгалах ба эмнэл зүйн багш, сургалтын албанаас суралцагчид үнэлгээнээс хамааран цаашид сургалтыг амжилттай дүүргэхэд шаардлагатай зохих заавар зөвлөмжийг өгнө.

7.3.1. Үнэлгээний төлөвлөгөө

Зайлшгүй суралцах	Үнэлгээний хэлбэр	Хамрах чиглэл	Арга, хэрэгсэл	Үнэлэгч/хэмжигч	Цаг хугацаа
1-6, 8	Явцын	Мэдлэг, чадвар	Дадлага: Mini-CEX, DOPS	Тасгийн эмч, эмнэл зүйн багш	Тойролт бүрт 5-8 удаа

7, 12, 13	Явцын	Мэдлэг, хандлага, багаар ажиллах чадвар	Дадлага: 360 хэмийн үнэлгээ, Ажиглалтын тэмдэглэл	Тасгийн эмч, эмнэл зүйн багш, ахлах сувилагч, өвчтөн	Тойролт бүрт 1-2
9-10,13	Явцын	Хандлага, чадвар	Дадлага: 360 хэмийн үнэлгээ, Ажиглалтын тэмдэглэл	Тасгийн эмч, эмнэл зүйн багш, өвчтөн	Тойролт бүрт 1-2
11, 12	Явцын, нэгдсэн	Хандлага, чадвар	Ажиглалт, аман: Ажиглалтын тэмдэглэл, бүтээлийн сангийн үнэлгээ, тайлан	Эмнэл зүйн багш, хариуцагч, сургалтын алба, шалгалтын комисс	Сургалтын хугацаанд байнга ба төгсөлтийн өмнө
1-13	Нэгдсэн	Мэдлэг, хандлага, чадвар	Дадлага, онолын мэдлэг, Тайлан, төгсөлтийн шалгалт: тест, гардан үйлдэл	Эмнэл зүйн багш, хариуцагч, сургалтын алба, шалгалтын комисс	Төгсөлтийн нэгдсэн шалгалт
1-13	Нэгдсэн	Мэдлэг, хандлага, чадвар	Төгсөлтийн тестийн шалгалтын хамгаалалт буюу аман шалгалт	Эмнэл зүйн багш, хариуцагч, сургалтын алба, шалгалтын комисс	Төгсөлтийн нэгдсэн шалгалт

7.3.2. Ажлын байранд суурилсан үнэлгээ (Workplace based assessment)

а) 360 хэмийн үнэлгээ (360 degree assessment)

Суралцагч эмчийн мэргэжилтний хувьд хэр "мэргэжлийн" (professional) байгааг үнэлэх зорилгоор сургалтын явцад тойролт бүрт үнэлнэ. Тойролт удирдсан багш нар болон сувилахуйн мэргэжилтэн, тасаг нэгжийн хамт ажилласан эмч, өвчтөн, эмнэлгийн мэргэжилтэн зэрэг нийт таван хүн тус тусдаа үнэлнэ. Үнэлгээ хийх хүмүүсийг сургалтын албанаас томилох ба үнэлгээний дүнг суралцагч эмч болон эмнэл зүйн сургагч багшид танилцуулж үнэлгээнд үндэслэсэн цаашдын зөвлөгөөг эмнэл зүйн сургагч багш суралцагчид өгнө.

б) Эмнэл зүйн дасгал үнэлгээ (Mini-CEX: Mini – Clinical Evaluation Exercise)

Өвчтөний шинжилгээнүүд болон эмнэл зүйг үндэслэн хэрхэн хими эмчилгээ төлөвлөх, эмчилгээний явцад болон дараах гаж нөлөө, хордлогын шинж тэмдгүүдийг шинжилгээ, эмнэл зүйд илрүүлэн таньж тойролт бүрт арваас доошгүй удаа үнэлгээ хийнэ. Эмнэл зүйн үнэлгээ хийх эмнэл зүйн сургагч багш эсвэл тухайн тасаг нэгжийн туршлагатай эмч нараас суралцагч өөрөө сонгон үнэлүүлэх ба сонгосон эмч шууд

ажиглаж, үнэлгээ хийсний дараа үр дүнг суралцагч эмчид танилцуулж цаашид юун дээр анхаарах, хэрхэн сайжрах зөвлөгөөг заавал өгнө.

в) Гардан үйлдлийн ур чадварын шууд ажиглалт/DOPS (Direct Observation of Procedural Skills)

Зайлшгүй сурах гардан үйлдлийн 80-аас багагүй хувийг бие даан хийж чаддаг болсныг эмнэл зүйн сургагч багш нотолж үнэлгээ хийнэ. Үнэлгээ хийх эмчийг эмнэл зүйн сургагч багш эсвэл тухайн тасаг нэгжийн туршлагатай эмч нараас суралцагч өөрөө сонгон үнэлүүлэх ба сонгосон эмч шууд ажиглаж, үнэлгээ хийсний дараа үр дүнг суралцагч эмчид танилцуулж цаашид юун дээр анхаарах, хэрхэн сайжрах зөвлөгөөг заавал өгнө.

г) Бүтээлийн сангийн (Portfolio) үнэлгээ

Суралцагч эмч сургалтын хугацааны лекц, бие даалтаар хийсэн болон семинар, журнал клуб, сургалтын тойрон үзлэг зэрэг сурах хугацаандаа хийсэн сурсан, бүтээсэн зүйлсийн тайлан материалыг цуглуулан “бүтээлийн сан” болгон хадгална. Үүнд хариуцагч болон эмнэл зүйн багштай зөвлөлдсөн, зөвлөгөө авсан тэмдэглэл, эмч нарын зөвлөгөөнөөс сурч ойлгосон мэдлэгийн тэмдэглэл зэрэг мөн багтана.

7.4. Үнэлгээний дүнг хянах

- 360 хэмийн үнэлгээний дүнг цаг тухайд нь авахуулж сургалтын алба хяналт тавьж хадгална. Үнэлгээний дүнг суралцагч эмч, эмнэл зүйн сургагч багшид танилцуулах ба бусадтай хуваалцахгүй байхыг анхааруулна.
- Mini-CEX болон DOPS үнэлгээний дүнг суралцагч эмч өөрөө хадгалж, тойролт бүрийн төгсгөлд сургалтын албанд Mini-CEX ба DOPS үнэлгээний дүнг хүлээлгэж өгнө.
- Эмнэл зүйн багш ажиглан “ажиглалтын тэмдэглэл” хөтлөнө. Энэ тэмдэглэлд семинарийн идэвх оролцооны үнэлгээг болон явцын бусад дадлага ажлын үед ажиглагдсан, суралцагчийн цаашдын хөгжил дэвшилд хэрэг болохуйц гэж үзсэн санал, үнэлгээг тэмдэглэн оруулж болно.
- Сургалтын алба үнэлгээний дүнг суралцагч болон хариуцагч, эмнэл зүйн сургагч багшид сургалтын нийт хугацааны дунд хагаст танилцуулах ба цаашид юунд анхаарах, төгсөх хүртэл юуг хийсэн байх талаар зөвлөгөө өгнө.

7.5. Сургалтын төгсөлтийг шийдвэрлэх

- Сургалтын хугацааны төгсгөлд “ажиглалтын тэмдэглэлүүд”-ийг эмнэл зүйн багшаас сургалтын алба авч нэгтгэн суралцагчийн хөгжил дэвшлийг үнэлэхэд мөн төгсөлтийн шалгалтын үнэлгээнд харгалзана.
- Тойролт бүрт хийгдсэн Mini CEX ба DOPS үнэлгээний дүнг нэгтгэсний үндсэн дээр суралцагч эмчийг төгсгөх эсэх шийдвэрийг сургалтын алба, хариуцагч ба эмнэл зүйн багшийн хамт гаргана. Үүнд тойролт бүрт хийгдсэн Mini CEX ба DOPS үнэлгээний дүн, 360 хэмийн үнэлгээний нэгдсэн дүн, суралцагчийн

сургалтын ирц, зайлшгүй таньж мэдэх шинж тэмдэг, өвчний тохиолдол, гардан үйлдлийн тоог харгалзан сургалтын төгсөлтийн эцсийн шийдвэрийг гаргана. Шийдвэр гаргах шалгуур нь:

- ❖ Зайлшгүй сургалтанд оролцсон байх өдрийн тоо буюу сургалтын ирц: Хөдөлмөрийн тухай хуульд заасан цалинтай амралтын тоо, хүндэтгэх шалтгаантай авах амралтын өдрийн тоог оруулаад сургалтын хугацаанд авах амралтын өдрийн тоог сургалтын тойролт тус бүрийн нийт өдрийн 20%-иас хэтрүүлэхгүй байна. Сургалтын ирц хангалтгүй бол тухайн тасарсан сургалтын өдөр, агуулгыг нөхүүлнэ.
- ❖ Зайлшгүй таньж мэдэх 11 шинж тэмдгийн онцлог ялгах шинж тэмдгүүдийг 1 жилийн турш оношилж, эмчлэн туршлага хуримтлуулсан байна. Зайлшгүй туршлага хуримтлуулсан байх шаардлагатай өвчний болон оролцсон хагалгааны тохиолдлын тоо нь тойролт бүрийн хуваарьт тусгагдсаны дагуу байна.
- ❖ Тойролтын дараа ба хагас жилээр эсвэл сургалтын хугацааны төгсгөлд суралцагчийг төгсгөх боломжгүй гэсэн шийдвэр гарсан тохиолдолд шалтгаан, цаашид сургалтыг хэрхэн төгсгөх талаарх шийдвэр, зөвлөмжийг сургалтын алба болон хариуцагч, эмнэл зүйн сургагч багш тухайн суралцагч эмчид тайлбарлаж өгнө.
- Сургалтын алба сургалтын хариуцагч болон сургалт явагдсан тасгийн эмнэл зүйн сургагч багш нараас оролцуулан шалгалтын комиссыг бүрдүүлж төгсөлтийн шалгалтыг зохион байгуулна.

НАЙМ. ХЭРЭГЖҮҮЛЭЛТ

(Хөтөлбөрийг нэвтрүүлэх ба хэрэгжүүлэх, хянах)

8.1. Хөтөлбөрийн хэрэгжүүлэлт ба сургалтын алба

- Суралцагчийн тоо, тойролтын хуваарийг эмнэл зүйн багшийн болон сургалт явуулах байгууллага, тасгийн үйл ажиллагаатай уялдуулан сургалтын алба сургалтын хариуцагч (mentor) эмчтэй хамтран зөвшилцөж хийнэ.
- Сургалтын эхэнд тойролт бүрийн сургалтын төлөвлөгөө (Program) болон хөтөлбөрийн (Curriculum) агуулгын уялдааг тодорхой ойлгох, эмнэлгийн үйл ажиллагаа, дотоод журам, эмчилгээ оношлогооны аюулгүй байдал, халдвар хамгаалалын талаарх гүнзгий ойлголт өгөх зорилго бүхий танилцуулга хичээлийг сургалтын албанаас зохион байгуулна.
- Хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардлагатай сургалтын төлөвлөгөө гаргах, эмнэл зүйн сургагч багшид чиглэсэн сургалт (Faculty Development), суралцагч эмчийн нийгмийн асуудалд дэмжлэг үзүүлэх, шаардагдах санхүүжилтийг төсөвт тусгах зэргийг сургалтын алба хариуцна.
- Хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт хийх шаардлагатай тохиолдолд сургалтын алба, сургалт явуулах байгууллага, сургалт хариуцагч, тасгийн сургагч багш нартай

хэлэлцэн нэмэлт өөрчлөлт хийнэ. Энэ тухай Эрүүл мэндийн хөгжлийн төвд албан бичгээр ажлын 10 хоногт багтаан мэдэгдэнэ.

8.2 Хөтөлбөрийн хяналт

- Суралцах нийт хугацааны туршид хөтөлбөрийн хэрэгжилт, суралцагчийн хөтөлбөрийн дүүргэлтийг сургалтын алба хянаж ажиллана.

8.3 Сургалтын танилцуулга

Сургалт эхлэхийн өмнө тойролт бүрийн сургалтын төлөвлөгөө (Program) болон хөтөлбөрийн (Curriculum) агуулгын уялпааг тодорхой ойлгох, төвийн үйл ажиллагаа, эмчилгээ, оношилгооны аюулгүй байдал, халдвар хяналтын талаар суралцагч эмчид гүнзгий ойлголт өгөх зорилго бүхий танилцуулга хичээлийг зохион байгуулна.

360 ХЭМИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Суралцагч эмчийн нэр _____

Үнэлгээ хийгч Эмнэл зүйн сургагч багш Сувилагч Бусад _____

Суралцагч эмчийг ажигласны үндсэн дээр бусдаас сонссон мэдсэн зүйл дээр бус, суралцагч эмчийн зан үйлийг хэр давтамжтай байсныг өөрийнхөө ажигласнаар оноо тавина уу.

<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4
Үнэлэх боломжгүй	Ховор ($\leq 19\%$)	Заримдаа (20-49%)	Ихэнхдээ (50-79%)	Бараг бүгд ($\geq 80\%$)

Өвчтөн/гэр бүлийн хувийн асуудлыг хүндэтгэдэг	NA <input type="checkbox"/>	1 <input type="checkbox"/>	2 <input type="checkbox"/>	3 <input type="checkbox"/>	4 <input type="checkbox"/>
Эмнэлгийн бичиг баримтыг гүйцэд, гаргацтай, цаг хугацаанд нь хөтөлдөг.					
Өвчтөний бие даасан байдлыг хүндэтгэж, өвчтөнд тохирсон хамгийн зөв шийдвэрийг гаргахыг хичээн зүтгэл гаргадаг.					
Хувь хүний онцлогийг харгалзан өвчтөнийг хүндэтгэн эмчилдэг.					
Өөрийн эмнэл зүйн ур чадварыг дээшлүүлэхийн тулд сургалт болон бусад боломжийг алдалгүй ашигладаг.					
Өөрийн анагаах ухааны онолын мэдлэгээ ахиулахын тулд бие дан суралцдаг.					
Эмнэлгийн бусад тасгийн эмч нартай хамтран ажилладаг.					
Эмнэлгийн доторх туслаж, үйлчилгээнд зохион байгуулах, манлайлах үүрэгтэйгээ ухамсарладаг.					

1 эсвэл 4 оноо тавьсан бол тухайн асуултын дагуу саналаа бичнэ үү.

Дүгнэлтийг тодорхой бичих хэрэгтэй. Жишээ нь: “Тэр найдваргүй” гэх нь тодорхой биш. Илүү хэрэг болох дүгнэлт нь “Тэр сүүлийн 3 удаагийн журнал клубын 2-т нь хэн нэгэнд урьдчилан мэдэгдэлгүйгээр оролцсонгүй”.

Өөрөөсөө асуу: “ Миний дүгнэлт цаашид сайжрахад нь суралцагч эмчид хэрэг болох уу?”

ЭМНЭЛ ЗҮЙН MINI-СЕХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Он, сар, өдөр / /

Суралцагч эмчийн нэр _____ Үнэлэгчийн нэр: _____

Үнэлгээ хийсэн газар: Тасаг Амбулатори Боолтын өрөө Хагалгааны өрөөӨвчтөний нас _____ Хүйс Эр Эм

Үнэлэх шинжүүд буюу өвчтөний зовиур В-шинж тэмдэг Цус алдалт, хурд Өвдөх
 Хаван Толгой хүзүүнд гарсан үүсвэр Саа саажил Амьсгал бачуурал (дуу сөөх)
 Амны хөндийн салстын өөрчлөлт Арьсны шарх, мэнгэ Сорви, наалдац (эмчилгээний дараах өөрчлөлт) Хамар, амны хөндий, залгиурын хавдрын шинж (шүд сулрах, залгих, ярих өөрчлөгдөх, хамар байнга битүүрэх)

Сайн талууд	Сайжруулахад чиглэсэн зөвлөгөө			Бусад санал
Сургалтын тухайн үед суралцагч эмчийн түвшинг ажигласнаа үнэлнэ үү. Бодит үзлэг хийх шардлагагүй тохиолдолд тэмдэглэнэ үү. <input type="checkbox"/>				Сайжрахын тулд хийх үйлдэл _____
Үнэлгээ	Хангалтгүй	Завсрын	Хангалттай	
Өвчний түүх нээх				
Бодит үзлэг				
Оношлогоо, эмчилгээний менежмент				
Харилцааны ур чадвар				
Эмнэл зүйн ерөнхий чадвар				

Үнэлэгчийн гарын үсэг _____ Суралцагч эмчийн гарын үсэг _____

Хангалттай гэж тодорхойлоход хэрэглэгдэх үзүүлэлтүүд	
Өвчний түүх авах, нээх	<ul style="list-style-type: none"> ▪ Ялган оношлогоо хийхүйц дэлгэрэнгүй авах ▪ Өвчтөний хэрэгцээг илрүүлж хариу өгдөг ▪ Өвчтөний дохио зангааг ойлгож тохиромжтой хариу үзүүлдэг
Бодит үзлэг	<ul style="list-style-type: none"> ▪ Ялган оношлогоо хийхүйц дэс дараатай бодит үзлэг хийдэг ▪ Үзлэгийн үед өвчтөнд таатай байх орчныг бүрдүүлдэг
Эмнэл зүйн менежмент	<ul style="list-style-type: none"> ▪ Зөв онош тавьдаг. ▪ Шаардлагатай шинжилгээг зөв төлөвлөж эмчилгээнд ашигладаг. ▪ Тохирсон эмчилгээг эхлүүлдэг ▪ Шаардлагатай бол тохирсон тасагт шилжүүлдэг
Харилцааны ур чадвар	<ul style="list-style-type: none"> ▪ Өвчтөн, түүний ар гэрийг сайн сонсдог. ▪ Өвчтөн, түүний ар гэр, асран хамгаалагчийн зовнилыг хуваалцан ойлгож хүндэтгэлтэй ханддаг. ▪ Өвчтөн, түүний ар гэр, асран хамгаалагчтай эелдэг, энгийн үгээр

Эмнэл зүйн ерөнхий чадвар	харьцдаг <ul style="list-style-type: none">▪ Өвчтөний таатай, аюулгүй байдлыг хангахад идэвх зүтгэл гаргадаг.▪ Би гэр бүлийнхээ хэн нэгнийг энэ эмчээр эмчлүүлэхийг зөвшөөрнө.
---------------------------------	--

Гардан үйлдлийн ур чадварын шууд ажиглалт буюу DOPS (Direct Observation of Procedural Skills) үнэлгээ

Он, сар, өдөр / /

Суралцагч эмчийн нэр _____ Үнэлэгчийн нэр: _____

Үнэлгээ хийсэн газар: Тасаг Амбулатори Хагалгааны өрөө Бусад өрөө

Өвчтөний нас _____ Хүйс Эр Эм

Зайлшгүй суралцах гардан үйлдлийн үнэлгээ:

Хангалттай бол √, Хангалтгүй бол X гэж тэмдэглэнэ.

- Химийн эм бэлдмэлийн харилцан үйлчлэл, фармакокинетик, фармакодинамикийг тайлбарлах, харьцангуй болон туйлын эсрэг заалтыг тодорхойлох
- Хими эмчилгээ хийх арга замууд (Intrathecal, Intraventricular)
- Карновский болон ДЭМБ-ын өвчтөний биеийн байдлыг үнэлэх шалгуураар хими эмчилгээ хийлгэж байгаа өвчтөнийг үнэлэх
- Хими эмчидлгээний үед үүсэх элэгний эмгэг өөрчлөлтийн зэргийг АНУ-ын Хавдрын институтын аргачлалаар тодорхойлох, химийн эмийн тунг бууруулах
- Давсаг, цээж, хэвлийн хөндийд хэсэг газрын хими эмчилгээ хийх
- Судасны гадуур хими тариа гарах үеийн авах арга хэмжээ, Портын катетрийн арчилгаа
- Хорт хавдартай өвчтөн бүрд тохирсон дагнасан хими эмчилгээ болон хими, туяа хосолсон эмчилгээний төлөвлөгөө боловсруулах
- Хорт хавдартай өвчтөний эмнэл зүй, лабораторийн шинжилгээг үндэслэн хими эмчилгээний үр дүн, гаж нөлөө, хүндрэлийг үнэлэх
-
-
-
-
-
-

Сайн талууд	Сайжруулахад чиглэсэн зөвлөгөө	Бусад санал
-------------	--------------------------------	-------------

--	--	--

Үнэлэгчийн гарын үсэг _____

Суралцагч эмчийн гарын үсэг _____